



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/202

Номгон

Малын халдварт өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын "Мал амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай" 2018 оны 225 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/19 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийг хооронд технологит хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулсугай.

2.Аймгийн хэмжээнд дархлаажуулалт хийснээс хойш 28 хоногийн хугацаанд тухайн мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг хүнсний зориулалтаар хэрэглэх, зах зээлд гаргаж борлуулах, нөөц бүрдүүлэхийг хориглосугай.

3.Дээрх ажлыг чанартай үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310513



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/204

Номгон

Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг
хэрэгжүүлэх ажлыг хүлээн авах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Т.Хишигбаатар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Хандсүрэн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын, Ой, ургамал, цөлжилт хариуцсан мэргэжилтэн

Ж.Дэлгэрмаа Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч

Б.Ганшүүдэр Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

Т.Отгонбаатар “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨӨТҮГазрын захирал

Ж.Цогтбаяр “Баянхонгор тохижилт үйлчилгээ” ОНӨӨАТҮГазрын менежер

Нарийн бичгийн дарга:

Б.Намуун Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, газрын харилцаа, уул уурхай хариуцсан мэргэжилтэн

2.Тэрбум ажлыг холбогдох хууль, журмын дагуу хүлээн авч, ажлын тайланг тухай бүрд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Т.Хишигбаатар)-д үүрэг болгосугай.

642310519

2.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

The image shows a rectangular official stamp. Inside the stamp, there is a central emblem consisting of a circle with a dot inside, flanked by two vertical bars. Above and below this emblem are vertical lines of text in Mongolian script. A handwritten signature is written across the center of the stamp, overlapping the emblem and the text. To the left of the stamp, the word 'ДАРГА' is printed. To the right, the name 'Д.МӨНХСАЙХАН' is printed, with a thin line pointing from the name to the signature in the stamp.